

ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА сэдэвт олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийн дүгнэлт, ЗӨВЛӨМЖ

Ерөнхий танилцуулга

Банк санхүүгийн мэрэгэжилтнүүд, эрдэмтэн судлаачдын дунд зохион байгуулсан “Зээлийн хүүг бууруулах эрх зүйн орчин, олон улсын туршлага” сэдэвт олон нийтэд нээлттэй хэлэлцүүлгийн гол дүгнэлт, зөвлөмжийг энэхүү танилцуулгад тусгав.

Тус хэлэлцүүлгийн үеэр Монголбанк болон ЭЗССХ-ээс зээлийн хүүний олон улсын харьцуулалт, эдийн засгийн болон хууль эрх зүйн орчны хүчин зүйлсийн талаар илтгэлүүдийг тавьсан. Мөн панел хэлэлцүүлгийн үеэр арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллагын төлөөллийг оролцуулж, зээлийн хүүнд хязгаар тогтоох нь ямар эрсдэлтэй талаар ярилцсан.

Уг хэлэлцүүлэг нь олон нийтэд нээлттэй бөгөөд УИХ-ын 2 гишүүн, арилжааны банк, судлаач эрдэмтэд, багш, оюутнууд зэрэг 90 орчим хүн оролцсон. Хэвлэл мэдээллийн байгууллагууд үйл ажиллагааг сурвалжилж, илтгэгчид болон оролцогчидтой ярилцлага хийсэн.

Цаашид хурлын үеэр хэлэлцүүлэгдсэн асуудлууд, дүгнэлт зөвлөмжүүд, илтгэлүүдийн гол агуулгыг олон нийтэд сурталчлан таниулах ажлууд хийгдэх төлөвлөгөөтэй байна.

Хөтөлбөр

Хэзээ: 2018.09.24-ны 10:00-14:00 цагийн хооронд

Хаана: Блю Скай зочид буудалд

Оролцогчийн тоо: 90 орчим

2018.09.24	Үйл ажиллагаа	
I хэсэг	Эдийн засаг, эрх зүйн орчин ба зээлийн хүү	
10:00-10:25	<ul style="list-style-type: none">○ <i>Илтгэл: Зээлийн хүү – Олон улсын харьцуулалт</i> (20 мин)○ Асуулт & Хариулт (5 мин)	Илтгэгч: С.Билгүүн (Монголбанкны Судалгаа, статистикийн газрын ахлах эдийн засагч)
10:25-10:50	<ul style="list-style-type: none">○ <i>Илтгэл: Зээлийн хүүг бууруулах эрх зүйн орчинг бий болгох олон улсын туршлага</i> (20 мин)○ Асуулт & Хариулт (5 мин)	Илтгэгч: С.Дэмбэрэл (Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал)
10:50-11:10	Кофены завсарлага	
II хэсэг	Зээлийн хүүг бууруулах нь	
11:10-12:00	<ul style="list-style-type: none">○ <i>Панел хэлэлцүүлэг: Зээлийн хүүг бууруулах оновчтой арга зам</i> (40 мин)○ Асуулт & Хариулт (10 мин)	Модератор: С.Дэмбэрэл (ЭЗССХ-ийн захирал) Панелистууд: <ul style="list-style-type: none">• Ж.Үнэнбат (Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал)• А.Алтансүх (ББСБ-уудын Холбооны ерөнхийлөгч)• М.Болд (Хас банкны гүйцэтгэх захирал)
12:00-12:25	<ul style="list-style-type: none">○ <i>Илтгэл: Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн төсөл</i> (20 мин)○ Асуулт & Хариулт (5 мин)	Илтгэгч : А.Туул (Монголбанкны Хууль эрх зүйн газрын Эрх зүйн бодлого, хэрэгжилтийн хэлтсийн захирал)

НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ПАНЕЛ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЕЭР ГАРСАН ГОЛ ДҮГНЭЛТ/ЗӨВЛӨМЖҮҮД

С.Дэмбэрэл (ЭЗССХ-ийн захирал)

- Зээлийн хүүнд хязгаар тогтоохоос өмнө хүүг бууруулахын тулд хийж болох олон зүйл бий.

Ж.Үнэнбат (МБХ-ын гүйцэтгэх захирал)

- Монгол улсын хувьд сонгуулийн мөчлөгөөс давсан урт хугацаанд макро эдийн засгийг тогтвортой байлгах нь зээлийн хүүг бууруулах гол нөхцөл болно
- Зээлийн хүүнд хязгаар тогтоох нь зээлийн хүртээмжийг бууруулах тул хэрэглэгчид, банкны харилцагчдын эрх ашигт нийцэхгүй
- Банкны бүх үр ашиггүй үйл ажиллагааны зардлыг бууруулах шаардлагатай ч энэ нь зээлийн хүүг бууруулахад нийлбэр дүнгээрээ 1%-ийн л нөлөөтэй.
- Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зөвлөмжийг МБХ боловсруулсан. Хууль бол хамгийн доод стандартыг тогтооно, харин энэхүү зөвлөмж дунд стандартыг тогтоож, банкууд өөрсдөө мөрдөх өндөр стандарт тогтоох хэрэгтэй.

А.Алтансүх (ББСБ-уудын Холбооны ерөнхийлөгч)

- Зээлийн хүү эдийн засгийн эрсдэлийг илэрхийлдэг тул хүүг бууруулна гэдэг нь эрсдэлийг хэрхэн бууруулах вэ гэдэг асуудал юм.
- ББСБ-уудын хувьд нэг эдийн засагчид ногдох зээлдэгчийн тоо бага, эх үүсвэрийн зардлыг бууруулах боломж хомс зэргээс шалтгаалаад суурь зардал өндөр. Үүний зэрэгцээ банкнаас зээл олгодоггүй эрсдэл өндөртэй зээлдэгчид үйлчилдэг тул хүү өндөр байдаг.
- ББСБ-уудын активын өсөлт 33%, харилцагч 155 мянгад хүрсэн. Өөрийн хөрөнгийн өгөөж 4.6%, активын өгөөж 3.5% байна. Хямралтай үед эрсдэл өсч, хүү өсдөг. Чанаргүй зээл 17% байснаа буурч 10% болоод байна.
- ББСБ-ууд бичил санхүүгийн олон улсын 7 зарчимтай нийцтэй зээлийн бодлого явуулж эхлээд байна. Зээлийг орлогын түвшинд нийцүүлж, эргэн төлөлтийн нөхцөлийг илүү ил тод ойлгомжтой болгох нь эрсдэлийг бууруулах нэг арга зам юм.
- Олон улсын туршлагаас харахад зохицуулалтгүй зах зээл дээр хүүний хязгаарлалт тогтоож, мөнгө хүүлэлтээс сэргийлдэг. Харин

ББСБ нь зохицуулалт, хяналтын дор үйл ажиллагаа явуулдаг, зээлийн хүү ч буурах хандлагатай байна. Хүчээр зээлийн хүүг зохицуулах нь том эрсдэл дагуулж, хүүг бууруулах боломжийг хязгаарлана.

М.Болд (Хас банкны гүйцэтгэх захирал)

- Зээлийн хүү гэдэг улс орон ямар байдалтай байна, түүнийг харуулдаг толь юм. Энэ үзүүлэлт олон зүйлээс хамаардаг. Макро эдийн засаг, банкны үйл ажиллагаа, бодлогын институци, хууль эрх зүйн орчин бүгд зээлийн хүүнд нөлөөтэй.
- Зээлийн хүү өндөр байгаатай хэн ч маргахгүй. Зээлийн хүртээмжийг хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг асуудал чухал.
- Дэлхийн 75 орны туршлагаас харахад зээлийн хүүнд хязгаар тогтоосноор зээлийн хүртээмж буурдаг. Хүү багатай зээл том компаниудад л олдож, бичил зээлдэгч нар хохирно.
- Хэрэглээний зээлийн өр орлогын харьцаа болон хугацаан дээр хязгаар тавьсан нь зүйтэй арга хэмжээ бөгөөд иргэдийг өрийн дарамтанд орохоос сэргийлэхэд чухал.

Б.Мэдрээ (ХХБ-ны ерөнхийлөгч)

- Зээлийн хүү Монголын бүх иргэн, аж ахуйн нэгжид хамаатай зүйл тул улс даяараа анхаарлаа хандуулах нь зүйтэй.
- Зээлийн хүү өндөр байгаад хэн буруутай вэ гэдэг гол асуудал биш. Харин яагаад өндөр байгаа вэ гэдгийг судлах шаардлагатай. Судалгаагаар учир шалтгааныг олох, ажил хэрэгчээр хандах хэрэгтэй.
- Зээлийн хүүг бууруулах бодлого иж бүрнээр гарч ирдэггүй, харин тус тусдаа тайлбарууд хийгддэг. Дэлхий даяар хамтарч ажиллаж байна, гэтэл Монголчууд яагаад чадахгүй байна вэ? Энэ зорилго хамтын ажиллагааны үр дүнд шийдэгдэнэ.
- Монгол даяар ядуу байгаа тул дайсан хайсан хүн их, арилжааны банкууд дайсан болчихдог. Мөнгө хүүлэгч, мөлжигч, шулагч, луйварчин гэдэг нэрийг зүүж байна.
- Банкуудыг дарамтлах 36 төрлийн хууль байна. Банк, банкны амьдралыг мэдэхгүй залуучууд төв банкинд ажиллаж байна. 22 настай сургууль төгсөөд 3 жил арилжааны банкинд ажиллаад, мастер хийн дахин 5 жил ажилласны дараа Монголбанкинд шалгалт өгч ордог байх хэрэгтэй.

- Пос/АТМ зэрэг давхардсан зардал олон байна. Үүнийг төв банкны зүгээс зохицуулж, нэгтгэх талаар арга хэмжээ авах хэрэгтэй.

Б.Жавхлан (УИХ гишүүн)

- Судалгаа ихэвчлэн академик түвшнийх байдаг тул Засгийн газрын ажилд тусдаггүй
- Зээлийн хүү нь улстөрийн халуун сэдэв болдог тул зээлийн хүүний бүтцийг системтэй ойлгох нь чухал.
- Хүүнд нөлөөлж байгаа хамгийн том шалтгаан бол макро бодлого. Иймд хүүнд нөлөөлж байгаа суурь өртгийг хэр сайн бууруулахаас зээлийн хүү амжилттай буурах эсэх нь шалтгаална.
- Зээлийн хүү өндөр байгаа нь төр сүүлийн 30-аад жилд үр дүнтэй байж чадаагүйн илрэл. Зээлийн хүүг хуулиар хязгаарлах нь нийгмийн дайралтыг аргацаах, олон нийтийн бухимдлаас зайлсхийсэн аргаа барсан зүйл. Зээлийн хүүнд хязгаар тавихгүй гэвэл улстөрийн эрсдэл ирнэ, ард олонд таалагдахгүй.
- Зээлийн хүүг бууруулахын тулд оношоо зөв тогтоох шаардлагатай. Үүнд УИХ, ЗГ юу хийх, ямар арга хэмжээ авах, эдийн засаг уул уурхайгаас хэт хамааралтай байдлыг хэрхэн бууруулах вэ гэдэг чухал. Үүнд шаардлагатай бүтцийн өөрчлөлтөө хийх хэрэгтэй.

Б.Баттөмөр (УИХ гишүүн)

- Зээлийн хүүг бууруулахд макро эдийн засгийн тогтвортой байдал чухал. Мөнгөний бодлого, ЗГ-ын бодлого, бүтцийн бодлого, төрийн албан хаагчдын ур чадвар өндөр байж эдийн засгийн өсөлт, инфляци, ханш тогтвортой байна. Эдгээр хүчин зүйлс тогтворгүй цагт зээлийн хүүг бууруулна гэдэг яриа утгагүй болно.
- С.Эрдэнэ гишүүний өргөн барьсан хуулийг 100% үгүйсгэж болохгүй. Макро эдийн засагт зах зээл өөрөө зохицуулж чадахгүй зүйл дээр төрийн зохицуулалт хэрэгтэй. Эдийн засгийн төрөлжилт, банкны өөрийн хөрөнгө г.м. зүйлсийг нэрлэж болно.
- Банкууд харилцагч хадгаламж эзэмшигчийн маш их мөнгийг удирдаж, Монголын эдийн засагт чухал нөлөө үзүүлдэг ч цөөн хүний эзэмшилд байдаг. Иймд банкууд олон нийтийнх болох ёстой. Энэхүү шаардлага, зохицуулалтыг төрөөс хийх хэрэгтэй.

ИЛТГЭЛҮҮДИЙН ТОЙМ/ҮР ДҮН

Сэдэв 1: ЗЭЭЛИЙН ХҮҮНИЙ ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА (С.Билгүүн, ССГ-ын ахлах эдийн засагч)

Зээл, хадгаламжийн хүү нь банкны шийдвэрээс хамаарах хэдий ч энэхүү шийдвэрт зах зээлийн бүтэц, санхүүгийн салбарын хөгжил, дэд бүтцийн хөгжил, хууль эрх зүйн орчин, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдал, мөнгөний бодлогын үр нөлөөтэй байдал зэрэг олон хүчин зүйлс тусгалаа олж байдаг. Эдгээр хүчин зүйлс нь улс орнуудад зээлийн хүүг яагаад ялгаатай байгааг тайлбарлана.

Манай орны хувьд зээлийн хүүний түвшин бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр буюу дунджаар жилийн 20 орчим хувьтай байна. Энэ нь манай улсын нэрлэсэн зээлийн хүүгийн түвшин бусад улстай харьцуулахад өндөр байгааг илтгэх юм. Харин Бразил болон Аргентин зэрэг улсуудын зээлийн хүүгийн түвшин маш өндөр буюу харгалзан 52 болон 26 хувьтай байна.

Зураг 1- Нэрлэсэн зээлийн хүүний харьцуулалт



Эх сурвалж: Дэлхийн банк 2016 он

Манай орны нэрлэсэн хадгаламжийн хүү 2016 оны байдлаар 13.3%-тай байгаа нь олон улсын ангилалаар нэлээд өндөр гэсэн ангилалд орж байна. Энэхүү үзүүлэлт нь манай хойд хөрш болох ОХУ-д жилийн 7%, харин өмнөд хөрш БНХАУ-д жилийн 1.5%-ийн үзүүлэлттэй байна.

Зураг 2 - Нэрлэсэн хадгаламжийн хүүний харьцуулалт




Эх сурвалж: Дэлхийн банк 2016 он


Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээл рүү шилжсэн улсуудтай Монгол улсын нэрлэсэн болон бодит зээлийн хүү, хадгаламжийн хүү, хүүний зөрүүний тоон мэдээг харьцуулан үзлээ.

Зээлийн нэрлэсэн хүүний зургаас үзэхэд Хорват, Чех, Унгар, Польш, Румын улсуудын зээлийн хүү нь хугацааны туршид манай улсаас бага байжээ. Хугацааны эхэн үе буюу 2007 онд эдгээр шилжилтийн эдийн засагтай улс орнуудад зээлийн хүү 6-13 хувьтай байсан бол манай улсад 22 орчим хувьтай байсан. Сүүлийн 5 гаруй жилийн хугацаанд эдгээр улсад зээлийн хүү харьцангуй буурч ирсэн бөгөөд 2016 онд зээлийн хүү 7-оос доош хувьтай байна.

Зураг 3 -Нэрлэсэн зээлийн хүү



Зураг 4- Нэрлэсэн хадгаламжийн хүү




Эх сурвалж: Дэлхийн банк


Хадгаламжийн хүү нь зээлийн хүүний суурь нөхцөл болдог. Зураг 4-өөс харахад хадгаламжийн хүүгийн түвшин нь манай орны хувьд зээлийн хүүтэй адилаар шилжилтийн эдийн засагтай орнуудаас өндөр тогтож иржээ. Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд хадгаламжийн хүү дунджаар 12-14 хувьтай байгаа бол Хорват, Чех, Унгар, Польш улсуудад 1-3 хувьтай тогтож байна.

Хүүний зөрүүний динамикийн зураг 5-д авч үзэхэд Монгол улс сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Хорват, Польш зэрэг зарим улсуудтай ойролцоо 5-8 хувийн орчимд хэлбэлзэж ирсэн байна. Эндээс үзэхэд манай улсын хүүний зөрүү нь шилжилтийн эдийн засагтай зарим улстай ойролцоо, ижил байжээ.

Зураг 5- Хүүний зөрүү



Зураг 6- Бодит зээлийн хүү




Эх сурвалж: Дэлхийн банк

Шилжилтийн эдийн засагтай улсуудын бодит зээлийн хүүг зураг 6-д харууллаа. Бодит зээлийн хүүний цаг хугацааны динамикаас үзэхэд манай улс бусад шилжилтийн эдийн засагтай улс орнуудтай ойролцоо, ижил түвшинд байсан байна. Гэвч сүүлийн 2 жилд бодит зээлийн хүү манай оронд бусдаасаа огцом өндөр гарсан нь инфляцийн түвшин бага байснаас үүдэлтэй.

Олон улсын хэмжээнд зээлийн хүү болон хуулийн чанарын индексийн хоорондын хамаарлыг Зураг 7-д дүрсэллээ. Зургаас харахад тухайн улсын хуулийн чанар болон зээлийн хүүний хооронд сөрөг хамаарал ажиглагддаг байна. Өөрөөр хэлбэл тухайн улсын хуулийн чанар өндөр байх нь зээлийн хүүг бага байлгах магадлалыг нэмэгдүүлдэг байна.

Зураг 7 - Нэрлэсэн хадгаламжийн хүүний харьцуулалт



Эх сурвалж: Дэлхийн банк 2016 он, Судлаачийн тооцоолол

Манай орны хувьд 1999 оноос зээлийн хүү жилийн 44%-иас эрчимтэй буурч, 2011 оны байдлаар 16.6% хүртэл буурсан. Хэдийгээр сүүлийн 7 жилийн хугацаанд хуулийн чанарын индекс манай орны хувьд өссөн боловч эдийн засгийн суурь хүчин зүйлсээс шалтгаалж зээлийн хүүний

хэмжээ буцан өсч, улмаар банкны салбарын зээлийн хүү сүүлийн 5 жилд өсөх хандлагатай буюу дунджаар жилийн 20 орчим хувьтай байна.

ИЛТГЭЛ 2: ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БИЙ БОЛГОХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА (С.Дэмбэрэл, ЭЗССХ-ийн захирал)

1. Хамгийн түрүүнд анхаарах ёстой зүйл бол хязгаарыг туйлын байдлаар эсвэл харьцангуй хэмжээгээр тогтоох дээр сонголт хийх асуудал юм. Абсолют буюу туйлын хязгаар тогтоож байгаа үед зээлийн бүх төрөлд үү эсвэл тодорхой төрөлд үү гэдгийг зөв сонгох нь чухал байдаг. Түүнчлэн нэгэнт тогтоосон бол энэ нь зээлийн хүү, инфляц, өрсөлдөөн гэх мэт хүчин зүйлээс хамаарсан хөдөлгөөнтэй байдалтай байх уу үгүй юу гэдэг сонголт чухал.

2. Харьцангуй хязгаар тогтоох үед ямар нэг бенчмарк үзүүлэлт буюу жишиг баримжаа болгох үзүүлэлтийг сонгох асуудал гардаг бөгөөд энэ нь Төв банкны репо хүү эсвэл тухайн улсад мөрдөгддөг libor хүүтэй ижил арга зүйтэй хүүний түвшин гэх мэтийг сонгон түүнээсээ илүү гарч болох максимум хэмжээ эсвэл үүн дээр тодорхой хэмжээний хувь хэмжээг нэмж тогтоодог.

3. Ингэж тогтоох нь өрсөлдөөнд ямар үр нөлөө үзүүлэх, эерэг болон сөрөг үр дагаврыг тооцох зэргээр Төв банк, Засгийн газрын хамтын ажиллагаа, хязгаар тогтоох шийдвэрийг хэрэгжүүлэх дэс дараалал, хяналт шалгалтын механизм зэргийг сайтар төлөвлөж тооцоолох шаардлагатай байдаг.

4. Ялангуяа зээлийн нийт зардлыг бүрэн тооцсон эсэх, хэрэглэгчдэд ил тод, ойлгомжтой байх учиртай дүрэм журам гаргах, түүнийхээ бүрэн хэрэгжилтийг хангах, хүлээлгэх хариуцлага гэх мэт олон төрлийн захиргааны акт хэрэгтэй болдог.

5. Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалсан хууль эрх зүйн орчин дутмаг улсад энэ чиглэлийн орчноо бүрдүүлэхгүйгээр дээд хязгаарыг шууд болон шууд бус хэлбэрээр тогтоох нь тэр бүр хүссэн үр дүнд хүрдэггүй бөгөөд энэ бол Монгол улсын хувьд онцгой анхаарах ёстой асуудал юм. Тухайлбал, ломбардын зээлийн асуудлыг буюу санхүүгийн үйлчилгээний асуудлыг Санхүүгийн зохицуулах хороонд хариуцуулаагүй үед барьцаалан зээлдэх үйл ажиллагаан дээр гарч буй мөнгө хүүлэлтийн хүүг хуулиар хязгаарлалаа ч түүний хэрэгжилт нь тодорхой бус болно.

6. Өөр нэг хувилбар нь Монгол улсын Иргэний хуульд зээлийн гэрээтэй холбоотой асуудлаар шүүхийн эрх мэдлийн одоо байгаа хүрээг

өргөтгөх, мөнгө хүүлэлтийн тухай тодорхойлолт оруулж өгөх, шүүх энэ чиглэлээр ямар шийдвэр гаргаж болохыг Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдэж болох юм. Ийм хувилбар бас бусад улсын хууль тогтоомжид байна. Гэхдээ энэ асуудлыг заавал шүүх гэхгүйгээр Иргэний хуульд нэгэнт мөнгө хүүлэлтийн тодорхойлолтыг хийгээд өгчихвөл арбитрийн шийдвэр ч гаргах боломжтой юм.

Дэлхийд одоогоор 76 улс ямар нэг хэлбэрээр зээлийн хүүний хязгаарлалт хийж байгаа бөгөөд 28 улс usury law буюу мөнгө хүүлэлтийн эсрэг хуультай, 24 улс зээлийн хүүний хууль, 9 улс холбогдох төрийн байгууллагад (Төв банк, шүүх, парламент, сангийн яам) де-факто хязгаарлалт (тааз) хийх эрх олгосон байна. Хууль эрх зүйн түгээмэл арга хэрэгслийн хувьд мөнгө хүүлэлтийн эсрэг хууль, иргэний хууль, эрүүгийн хууль гэх мэт арга хэрэгслүүдийг ашиглаж байна. Хүүгийн түвшинг авч үзэхдээ их төлөв бодит хүү, зээлийн хүүний бодит өртөг хоёроос хязгаарлалт хийх хүүгээ сонгож байгаа бөгөөд зарим улсад гэхдээ нэрлэсэн хүүгийн түвшинг ашиглаж байна. 24 улсад таазыг абсолют буюу туйлын хэмжээгээр баталж байгаа бол 32 улсад харьцангуй байдлаар таазыг тогтоож байна. Харьцангуй байдлаар тааз тогтоож буй улсуудын ихэнх нь дотооддоо бенчмарк үзүүлэлт (Төв банкны репо хүү гэх мэт) –ээр жишиг болгож хязгаарлалтыг хийж байна. Ингэхдээ таазыг зээлийн тодорхой төрлүүдээр (хэрэглээний зээл голцуу), санхүүгийн институцийн төрлөөр (ББСБ, ломбард голцуу) ялгавартай тогтоож байна. Энэ бүх зохицуулалтын ерөнхий үр дүнг харвал эерэг, сөрөг аль аль нь байгаа үр нөлөөтэй байгааг анхаарах хэрэгтэй юм. Дэлхийн банк тиймээс доорх чиглэлүүдээр бодлогын зөвлөмж өгдөг бөгөөд эдгээр нь:

1. Өрсөлдөөн
2. Санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалт
3. Санхүүгийн хэрэглэгчийн боловсрол
4. Зээлийн мэдээлэл
5. Бичил зээлийн бүтээгдэхүүн
6. Зээлийн хүүний хязгаарлалт буюу тааз тогтоох

Эдгээр чиглэлээс харахад Монгол улсын хувьд эхний 5 чиглэлээр хангалттай хэмжээнд бодлогын арга хэмжээ, эрх зүйн орчин бүрэлдүүлээгүй мөртлөө шууд 6-р чиглэл буюу сөрөг үр нөлөө нь их байгаа зээлийн хүүний тааз тогтоох, ингэхдээ шууд хуулиар, абсолют байдлаар тоо заах хуулийн төсөл яригдаж байгаа нь арга зүйн хувьд

төдийгүй бодлогын хандлага талаасаа зохистой бус, иж бүрэн бус байгаа нь тодорхой байна.

ИЛТГЭЛ 3: САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ (А.Туул, ХЭЗГ Эрх зүйн хяналт, хэрэгжилтийн хэлтсийн захирал)

1. Асуулт: Хуулийн төсөлд иргэдээс гадна аж ахуйн нэгжид хамаарах уу? Аж ахуйн нэгжийг яагаад санхүүгийн хэрэглэгч гэж үзэхгүй байгаа юм бэ?

"Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай" хуулийн төсөл нь зөвхөн өөрийн болон гэр бүлийн хэрэгцээндээ зориулан санхүүгийн бүтээгдэхүүн үйлилгээ авч буй иргэдрүү чиглэж, холбогдох зохицуулалтыг оруулахаар ажлын хэсэг зорьж ажилласан байгаа. Монголбанк АХБ-тай хамтран 2017 онд *"Санхүүгийн салбарын хөгжил, тогтвортой байдлыг дэмжих"* төслийн бүрэлдэхүүн хэсэг болох *"Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нь"* төслийг хүрээнд гарсан зөвлөмжөөр АХБ-аас "Санхүүгийн хэрэглэгч" гэдгийг иргэд байна гэж тодорхойлж үүнд хамаарах эрх зүйн орчиныг бүрдүүлэхийг зөвлөсөн байдаг. Мөн аж ахуйн нэгж нь иргэнийг бодвол хүний нөөц бололцоо, мэдлэг мэдээлэл ихтэй байдаг тул энэ тал дээр хамгийн их эрх нь зөрчигддөг сүбъект нь иргэн гэж үзэж байгаа юм. Хуулийн төсөлд орж байгаа бас нэг шинэлэг зохицуулалт бол Монгол Улсад анх удаа санхүүгийн маргааныг шүүхийн бус замаар төрөөс байгуулагдсан мэргэшсэн этгээд шийдвэрлэхээр болж байгаа. Энэ мэргэшсэн этгээдэд зөвхөн иргэн бус аж ахуйн нэгж байгууллага ч гэсэн гомдол гаргах, зөрчигдсөн эрхээ хамгаалуулах эрх нь нээлттэй байлгахаар зохицуулж байгаа.

2. Асуулт: Хуулийн төсөлд санхүүгийн боловсролын талаар орсон шалтгаан яг юу вэ? Төв банк санхүүгийн боловсрол олгох нь зөв үү?

Санхүүгийн харилцаанд нэг талаас санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь өөрийн үзүүлж буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйчилгээний талаар хангалттай мэдээ, мэдээлэлээс гадна түүний ард бүтэн баг ажиллаж байдаг тул санхүүгийн эрсдэлд орох магадлал хамаагүй бага байдаг. Харин нөгөө талд тухайн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн санал болгож буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч буй иргэдэд хангалттай мэдээлэлээс гадна ирээдүйд учирч болох эрсдэлээс өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах санхүүгийн боловсрол тийм ч их байдаггүй тул санхүүгийн хэрэглэгчийн санхүүгийн боловсрол дээшилснээр өөрийн санхүүгийн нөхцөлд тохирох бүтээгдэхүүн, үйлчилгээнээс сонгож

хэрэглэх, санхүүгийн зөв дадал зуршил бий болно гэж үзэж байна. Мэдээж энэ дадал зуршил хүн бүрт бий болсоноор санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн чанаргүй актив хөрөнгө багасах цаашлаад улс орны санхүүгийн урт хугацааны тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлнэ.

Дэлхий нийтээр иргэдийнхээ санхүүгийн боловсролд эрчимтэй анхаарах болсон ба 2017 оны байдлаар нийт 60 улс энэ чиглэлийн үндэсний хөтөлбөр болон стратери гаргасан байдаг. Манай улын хувьд "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг Монголбанк, Сангийн яам, БСШУЯ, СЗХ-ны 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хамтарсан тушаалаар баталсан. Мөн "Монгол улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр" -ийн Санхүүгийн хүртээмж дэд ажлын хэсгийн *Зорилт 6.3.2. "Олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдтэй үр дүнтэй хамтран ажиллах, мэдээлэл солилцох нөхцлийг бүрдүүлнэ"*. гэж заасны дагуу энэ чиг үүргийг Монголбанк дээрх бусад төрийн зохицуулагч байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна. Хуулийн төсөлд ч мөн ялгаагүй "Санхүүгийн боловсрол"-той холбоотой хэсгийг Сангийн яам, БСШУЯ, СЗХ-ны хамтаар хэрэгжүүлэхээр зохицуулсан байгаа.

Дүгнэлт:

Санхүүгийн үйлчилгээ нь хүн бүрт хүрдэг хамгийн өргөн хүртээмжтэй салбар тул хэрэглэгчдийн мэдлэг, мэдээлэл энэ салбарын урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй юм байна гэсэн дүгнэлтийг 2008 онд болсон дэлхийн санхүүгийн хямралын дараа хийж, олон улсын хэмжээнд асуудлыг дахин шинэ түвшинд авч үзэх болсон.

Монгол Улсын хувьд Монголбанк, СЗХ, ШӨХТГ өөрсдийн эрх хэмжээний хүрээнд хяналт тавьж ажилладаг ч үүрэг функц нь давхардсан, нэгдсэн тогтолцоогүй, хамтын ажиллагаа сул, хөгжил нь хангалтгүй, дэлхийн нийтийн хандлагад нийцэх тогтолцоо бүрдээгүй зэрэг тулгамдсан асуудлууд байсаар байна.

Дэлхийн банкнаас 2012 онд манай улсад хийсэн *"Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн суурь боловсролын өнөөгийн байдлын оношлогоо дүгнэлт"* гэсэн судалгаагаар санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог үндсэндээ хангалтгүй байна гэж дүгнэсэн нь дээрх нөхцөл байдлыг илтгэн харуулсан явдал байв.

Түүнээс хойш 2016 оны 3 дугаар сард Монголбанк, Азийн хөгжлийн банкны хооронд Монгол Улсын Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дэмжих, санхүүгийн хэрэглэгчийг хамгаалж ажиллах тухай

“Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулж, төсөл хэрэгжүүлэгчээр Монголбанк голлох үүрэгтэй ажиллаж эхэлсэн юм.

Энэ хугацаанд Монголбанк, АХБ-тай хамтран 2017 онд үндэсний болоод олон улсын хэмжээний нийт 3 удаагийн уулзалт, семинарыг зохион байгуулсны үр дүнд АХБ-аас Монгол Улсын санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн болон зохицуулалтын өнөөгийн тогтолцоо ба түүнийг шинэчлэх талаарх зөвлөмжийг өгсөн байна.

Дээрх зөвлөмжөөр Монгол Улсыг "санхүүгийн хэрэглэгч" гэсэн шинэ нэр томъёог нэвтрүүлж, үүнийг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэхийг зөвлөж үүний дагуу Монголбанкнаас санаачлан 2018 оны 01 дүгээр сараас эхлэж "Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай" хуулийн төслийг боловсруулах ажил хийгдэж эхэлсэн.